

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 00001308

| | | | |
|---|-------------------------------|--------------------------------------|-----------------------|
| Огноо: | 2022-09-07 | Дансны дугаар | Дүн /тоогоор/ |
| Төлөгч: | Диспетчерийн үндэсний төв ХХК | Дебит | 10,495,000.00 |
| Төлөгчийн: | Худалдаа Хөгжлийн Банк | 406002860 | |
| Хүлээн авагч: | МУХАУТ | Кредит | |
| Хүлээн авагчийн: | ХААН Банк | 5112170005 | |
| Мөнгөний дүн тоогоор (үсгээр) | 10,495,000.00 | ... хоногийн ... хувийн торгууль ... | |
| (Арван сая дөрвөн зуун ерэн таван мянган төгрөг 00 мөнгө) | | | ... төгрөг ... мөнгө |
| Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн: | | | Дүн (торгуулийн хамт) |
| Дагалдах баримтын № | Огноо: 2022-09-07 | **** | |
| Төлбөрийн зориулалт (барааны болон ажил үйлчилгээний нэр) | | | Гүйлгээний утга |
| Үйлчилгээний төлбөр /РД:2699877/ | | | (Төлбөрийн зориулалт) |
| Гүйцэтгэх захирал: <i>Т. Валцраагийн</i> Банкнд гүйлгээ хийсэн ... оны ... сарын ... Ерөнхий нягтлан бодогч: <i>[Signature]</i> 2022-09-07 ХХБ банк Хүний нөөц (тэмдэг, гарын үсэг) №04 | | | Төлөх хугацаа |
| Тамга ДИСПЕЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ХХК АТА4807 2699877 9020110314 | | | Төлбөрийн ээлж |

НЭХЭМЖЛЭХ №

НХ Маягт Т-1

0000977



Байгууллагын нэр: МҮХАҮТ
Хаяг: Хан-Уул дүүрэг, 15-р хороо, "Махатма Ганди"-н гудамж
Утас: 77277070
Регистр: 1000381
И-мэйл: finance@mongolchamber.mn

"ЗVТол" ТӨХК 2699877

/Төлөгч байгууллага/

Нэхэмжилсэн огноо:

| № | Гүйлгээний утга | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---------------------|-----------------------|------------|-------------|------------|
| 1 | Арга хэлжээний төлбөр | 1 | 10,495,000 | 10,495,000 |
| Төлбөрийн нийт дүн: | | | | |
| Үсгээр: | | | | |

/Төлбөр хийх агаарын зоног/

ХААН БАНК: 5112 003 124 /MNT/
5112 036 092 /MNT/

5112 170 005 /MNT/

Бусад данс:

Нягтлан бодогч: _____





ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар Б/10/1

Улаанбаатар хот

Зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйл 5.1, 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3, Засгийн газрын 2022 оны 203-р тогтоолын 1.3, ТУЗ-ийн 2019 оны 26-р тогтоол, Хамтын гэрээний 6.2, компанийн 2022 оны Ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний системийн өвлийн горим төлөвлөлт сэдэвт салбар зөвлөгөөнийг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 16-ны өдрийг дуустал хугацаанд оролцох ажилтнуудыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Зөвлөгөөний зардал болох 10,495,000 (арван сая дөрвөн зуун ерэн таван мянга) төгрөгийг сургалтын зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан (Т.Бямбажав)-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын алба (Б.Биндэръяа)-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.Балжинням



БАТЛАВ.
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ДАРГА
..... /Т.ДҮҮРЭН/



БАТЛАВ.
"ДҮТ" ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
..... /Г. БАЛЖИННЯМ/



ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

2022 оны 09 сарын 05-ны өдөр

№ 22-06/146

Улаанбаатар хот

Нэг.Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээг нэг талаас "МҮХАУТанхим" РД:1000381 /цаашид "Танхим" гэх/-ыг төлөөлж, Захиргаа хүний нөөцийн газрын мэргэжилтэн Ж.Долгоржав, нөгөө талаас "ДҮТ" ТӨХХК РД: 2699877 /цаашид "Захиалагч" гэх, хамтад нь "Талууд" гэх/-ийг төлөөлж Горим төлөвлөлт, тооцооны албаны дарга Х.Болд-Эрдэнэ нар харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.
- 1.2 Гэрээний зорилго нь Танхим өөрийн "Их танхим"-д захиалагчийн хүсэлтээр 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 08.00-18.00 цаг хүртэл /нийт 10 цаг/-ийн "Эрчим хүчний системийн өвлийн горим төлөвлөлт" сэдэвт салбар зөвлөгөөн зохион байгуулах байраар хангах, үйлчилгээ үзүүлэх, Захиалагч нь түүнтэй холбогдон гарах төлбөр тооцоог төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.3 Гэрээний хугацаанд талуудын өмчлөгч, эзэмшигч болон удирдлага өөрчлөгдсөн эсэхээс үл хамаарч энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр.Захиалгын хуудас, захиалга хийх нөхцөл

- 2.1. Гэрээний дагуу зохион байгуулагдах арга хэмжээний хүрээнд Танхимын зүгээс үзүүлэх үйлчилгээ, дагаж мөрдөх журам нь Хавсралт №1 маягтын дагуу захиалгын хуудсанд бүрэн бичигдсэн байна. Захиалгын хуудас нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 2.2. Захиалагч арга хэмжээ зохион байгуулагдахаас ажлын 3 хоногийн өмнө арга хэмжээ зохион байгуулах заал, танхимын засалт /план зураг гаргах/, оролцогчдын тоо, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт, эхлэх, дуусах цагийг эцсийн байдлаар Танхимд мэдэгдэнэ.
- 2.3. Танхим захиалагчийн хүсэлтийн дагуу дараах тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй ашиглуулна. Үүнд: проектор, микрофон, хурлын зориулалт бүхий дууны төхөөрөмж, цагаан самбар, өрөөний энгийн гэрэлтүүлгийн төхөөрөмж, тайз, индэр, ширээ, ширээний бүтээлэг болон сандал багтана.
- 2.4. Гэрээний 2.3-т заасан тоног төхөөрөмж тухайн арга хэмжээний хувьд тоо ширхэг хүрэлцэхгүй, эсвэл өөр бусад нэмэлт тоног төхөөрөмж шаардлагатай бол Захиалагч тал Танхимтай харилцан тохиролцож өөрийн зардлаар гаднаас түрээсэлж болно.

Гурав.Төлбөр, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Гэрээний нийт үнийн дүн **10 495 000₮** /арван сая дөрвөн зуун ерэн таван мянга/ төгрөг болно.
- 3.2 Гэрээ батлагдсан өдөр гэрээний үнийн дүнгийн 30%-ийг төлөх бөгөөд үлдэгдэл 70%-ийг арга хэмжээ болохоос 2 /хоёр/ хоногийн өмнө шилжүүлнэ.
- 3.3 Энэхүү гэрээний 3.2-д заасан хугацаанд түрээслүүлэгчийн дансанд төлбөр ороогүй нөхцөлд түрээслэгчид заал танхимыг дурдсан хугацаанд олгохгүй болно.
- 3.4 Төлбөрийг МҮХАУТ-ын ХААН банк дахь 5112170005 тоот төгрөгийн дансанд төлнө.

- 3.5 Захиалагч арга хэмжээ зохиогдохоос 3 хоногийн өмнө захиалгаа цуцлах тохиолдолд урьдчилгаа төлбөрийн 20 хувийг Танхим суутгаж тооцно.
- 3.6 Гэрээний дагуу төлбөрийг хугацаанд нь Түрээслэгч талд шилжүүлээгүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцно.
- 3.7 Захиалагч гэрээнд тусгагдаагүй нэмэлт үйлчилгээ болон Захиалагч талаас учруулсан хохирлын төлбөрийг арга хэмжээ дууссанаас 3 хоногийн дотор Танхимд төлнө.
- 3.8 Захиалагч гэрээгээр тохирсон хугацаанд заал, танхимыг суллаж өгөх ба хугацаа хэтрүүлбэл тухайн заалны 1 цаг тутмын үнийг нэмж Танхимд төлнө.
- 3.9 Захиалагч талын үйл ажиллагааны бэлтгэл хийх цаг 1 цаг байна. 1 цагаас дээш хугацаагаар бэлтгэл хийх тохиолдолд түрээсэлсэн танхимын нэг цаг тутмын түрээсийн төлбөрийг /бүтэн/ нэмэлтээр Танхимд төлнө.

Дөрөв.Танхимын эрх, үүрэг

- 4.1. Захиалагч Танхимын эд хөрөнгөнд гэмтэл, хохирол учруулсан, дутаасан, үрэгдүүлсэн бол хохирлыг үл маргах журмаар бүрэн төлүүлэх;
- 4.2. Захиалагчийн үйл ажиллагаа, оруулж ирсэн тоног төхөөрөмж, эд зүйлсийн чанар гэмтэл, түүнээс үүсэх үр дагаврыг хариуцахгүй;
- 4.3. Захиалагчийн зочид болон оролцогч нар эмх замбараагүй үйлдэл хийх, архи дан согтуурах, танхайрах зэргээр Танхимын бусад зочид, үйлчлүүлэгч, ажилтны ая тухтай байдалд нөлөөлөхүйц үйлдэл гаргасан тохиолдолд Захиалагч талд мэдэгдэн энэ үйлдлийг зогсоохыг шаардах, эсвэл цагдаад мэдэгдэж шуурхай арга хэмжээ авахуулах;
- 4.4. Захиалагчийн зохион байгуулж буй арга хэмжээ тогтоосон хугацаанаас өмнө зогсох, тасалдах, дуусах тохиолдолд гэрээний нийт үнийн дүнгээр төлбөрийг төлүүлэх;
- 4.5. Захиалагч нэмэлт үйлчилгээ авснаар энэхүү гэрээгээр тохирсон нийт үнийн дүнгээс хэтэрсэн төлбөр гарсан, мөн захиалагчийн зочид болон оролцогч нарын санаатай болон болгоомжгүй үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- 4.6. Захиалагч арга хэмжээний нарийвчилсан хөтөлбөрөө урьдчилан энэхүү гэрээнд заасан хугацаанд Танхимд бичгээр өгөөгүйгээс болж арга хэмжээний явцад гарсан ямар нэгэн алдаа, хохирлыг хүлээхгүй байх;
- 4.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 4.8. Захиалагч урьдчилан захиалсан тохиолдолд энэхүү гэрээний 2.3-д заасан тоног төхөөрөмжөөр үйлчлэх;
- 4.9. Өөрийн эзэмшлийн газарт арга хэмжээний үеэр саад болох засвар, сайжруулалтын ажлыг зөвхөн давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд хийхгүй байх;
- 4.10. Арга хэмжээтэй холбоотой аливаа гомдлыг 3 хоногийн дотор нотлох баримтад үндэслэн шийдвэрлэж хариу мэдэгдэх.

Тав.Захиалагчийн эрх, үүрэг

- 5.1. Захиалагч дараах эрхтэй:
 - 5.1.1. Захиалгыг баталгаажуулснаас хойш 3 хоногийн хугацаанд нийт захиалгын үнийн дүнгийн 30 хувьд өөрчлөлт оруулах;
 - 5.1.2. Өөрийн буруугаас хөтөлбөр өөрчлөгдөх, хугацаанаасаа хоцорч эхлэх, оройтож дуусах, захиалгаас гадуур үйл ажиллагаа явагдах шаардлага гарсан тохиолдолд Танхимын зөвшөөрлөөр нэмэлт цаг сунгах, түүнтэй холбогдох нэмэлт төлбөрийг төлж, үйлчилгээ авах;
- 5.2. Захиалагч дараах үүргийг хүлээнэ.
 - 5.2.1. Танхимын эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг эвдэх, гэмтээх, дутаах, үрэгдүүлэх зэрэг тохиолдолд төлбөрийг төлөх;
 - 5.2.2. Арга хэмжээ зохион байгуулах үед гаднаас оруулсан аливаа техник хэрэгсэл /өсгөгч, пульт, синхрон орчуулгын төхөөрөмж, микрофон гэх мэт/, тоног төхөөрөмжийг Танхимын хариуцсан ажилтнаар хийлгэх, хийлгээгүй болон горимын дагуу

- 5.2.3. Гэрээний хугацаанд гуравдагч этгээдээр гэрээт үйлчилгээ хийлгэх тохиолдолд Танхимд энэхүү үйлчилгээний талаар нарийвчилсан мэдээллийг бичгээр өгөх, гуравдагч этгээдийн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг өөрөө хариуцах;
- 5.2.4. Зочид болон оролцогч нарын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангах;
- 5.2.5. Өөрийн зочид болон оролцогч, бусад зочид үйлчлүүлэгч эсвэл 3-дагч этгээдэд болон бие биедээ аливаа санаатай болон болгоомжгүй үйлдлийн улмаас учруулсан хохирлыг бие даан хариуцах, нөхөн төлөх;
- 5.2.6. Гаднаас авчирсан тоног төхөөрөмж нь чанарын шаардлага хангасан, стандарттай байх ба, тэдгээрийг танхим руу оруулах, гаргах, зөөвөрлөх, суурилуулах, угсрах, тохиргоо хийх, ажиллуулах, ашиглах үед аюулгүй байдлыг хангах, хангаагүйгээс өөрсдөө болон Танхимд учирсан бодит хохирлыг бүрэн хариуцах;
- 5.2.7. Энэхүү гэрээний 5.2.3, 5.2.4, дахь хэсэгт заасны дагуу танхимын эд хөрөнгөнд гэмтэл учруулсан, дутаасан, алга болгосон, үрэгдүүлсэн бол хохирлыг засварлах, нөхөн сэргээхэд зарцуулах зардлын хамт нийт гарсан хохирлыг бүрэн төлөх;
- 5.2.8. Хуульд заасан бусад эрх, үүрэг.

Зургаа.Гэрээ цуцлах

- 6.1. Дараах тохиолдолд танхимын санаачлагаар гэрээг цуцална.
 - 6.1.1. Захиалагч нь энэхүү гэрээнд заагдсан нөхцөлүүдийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй зөрчсөн;
 - 6.1.2. Аливаа өөрчлөлттэй холбоотойгоор гэрээний үнэнд өөрчлөлт орох тохиолдолд Захиалагч тал шинэ үнийн саналыг хүлээн зөвшөөрөөгүй татгалзсан;
 - 6.1.3. Энэхүү гэрээний 3.2 дахь хэсэгт заасан үлдэгдэл төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд
 - 6.1.4. Хуульд заасан үндэслэл журмын дагуу.
- 6.2. Гэрээг цуцлах талаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэх ба мэдэгдлийг гэрээнд заасан хаяг руу и-мэйлээр явуулснаар хүлээлгэн өгсөнд тооцно.
- 6.3. Гэрээ цуцлах мэдэгдлийг хүлээн авснаас 1 хоногийн дотор хариу мэдэгдэх ба мэдэгдээгүй тохиолдолд гэрээ цуцлагдсанд тооцно.
- 6.4. Гэрээний талуудын аль нэг нь арга хэмжээ эхлэх хугацаанаас 21 болон түүнээс дээш хоногийн өмнө гэрээг цуцлах тохиолдолд цуцлалтын төлбөр харилцан төлөхгүй.
- 6.5. Энэхүү гэрээний хугацаа дуусгавар болох, гэрээ цуцлагдах нь захиалагч тал танхимд хийх ёстой төлбөр тооцоо, алдангиас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Долоо.Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээнд оролцогч талуудаас үл хамаарах байгалийн үзэгдэл, төрөөс явуулж буй бодлого /хууль, эрх зүйн акт/, нийгмийн хямрал зэрэг шалтгаанаар талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар 24 цагийн дотор бие биедээ мэдэгдэх үүрэгтэй бөгөөд түүний улмаас ямар нэгэн хор хохирол учирсан тохиолдолд аль аль нь хариуцлага үл хүлээнэ.
- 7.2. Танхимын арга хэмжээ зохион байгуулагдах өрөө, танхимыг хэрэгцээт цахилгаан, халуун, хүйтэн усыг шугам сүлжээний газрууд тасалснаас үүдэн гарсан үйлчилгээний доголдлыг танхим хариуцахгүй.

Найм.Маргаан шийдвэрлэх, бусад

- 8.1. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж талууд гэрээний үүргээ зохих ёсоор бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болно.

- 8.2. Гэрээгээр зохицуулаагүй талуудын хоорондын бусад харилцааг энэ гэрээнд заасан нөхцөл, зарчмын хүрээнд Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохицуулна.
- 8.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд зөвхөн бичгээр оруулах ба уг нэмэлт өөрчлөлт нь талуудын харилцан тохиролцож, гарын үсэг, тамгаар баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.4. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд юуны түрүүнд хэлэлцээ хийх замаар эрмэлзэх бөгөөд хэлэлцээ хийх замаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.5. Энэхүү гэрээгээр тогтоосон үнэ, гэрээний нөхцөл, арга хэмжээний хөтөлбөр, үйлчлүүлэгчийн нэрсийн жагсаалт, холбогдох бусад баримт, материалын талаар талууд амаар болон бичгээр 3-дагч этгээдэд дамжуулахгүй, задруулахгүй байх үүрэгтэй.
- 8.6. Гэрээний хугацаа дууссан, гэрээ цуцлагдсан нь талуудын төлбөр, алданги, торгууль, хохирол төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 8.7. Талууд аль нэг талдаа санал гаргах, гэрээнд өөрчлөлт оруулах тухай саналаа зөвхөн бичгээр хүргүүлнэ.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

МҮХАҮТ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

Хянасан: МҮХАҮТ-ын Тамгын дарга
Б.Батболд



Хянасан: Захиргаа, хүний нөөцийн газрын
дарга Н.Долгормаа




Утас: 99096809

Захиргаа, хүний нөөцийн газрын
мэргэжилтэн Ж.Долгоржав



Утас: 99154010

Санхүү бүртгэлийн газрын дарга
Б.Ариунтуяа



Утас: 99083423

Хаяг: ХУД, 15-р хороо, Махатма Гандигийн
гудамж МҮХАҮТанхим

Утас: 70277070 /7/, 99022590, 99102226

Имэйл: operation@mongolchamber.mn

Цахим хуудас: www.mongolchamber.mn

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Захиргаа, удирдлагын албаны дарга
Б.Биндэрьяа



ГТТА-ны дарга Х.Болд-Эрдэнэ



Утас: 9907-9579

Санхүү, эдийн засгийн албаны дарга
Т.Бямбажав



Утас: 8806-5099

Хаяг: ХУД, 3-р хороо, 17060, Чингисийн
өргөн чөлөө, Засгийн газрын 14-р байр

Имэйл: bolderdene@ndc.energy.mn

ЗАХИАЛГЫН ХУУДАС

Захиалагч байгууллага: "ДҮТ" ТӨХХК

Регистрийн дугаар: 2699877

Хугацаа: 2022 оны 09 сарын 15-ны өдөр /08.00-18.00 цаг/

Арга хэмжээний нэр: "Эрчим хүчний системийн өвлийн горим төлөвлөлт" салбар зөвлөгөөн

Захиалагч талаас харилцах ажилтны нэр: Албаны дарга Х.Болд-Эрдэнэ

Захиалагч талаас харилцах ажилтны утасны дугаар: 9907-9579

| № | Захиалгын төрөл | Хэмжих нэгж | Нэгж үнэ | Нийт үнэ /төгрөг/ |
|-----------------|----------------------------|-------------|----------|--------------------|
| 1 | Заалны түрээс / дэлгэцтэй/ | 10 цаг | 700 000₮ | 7 000 000₮ |
| 2 | Онлайн хурал /ZOOM/ | 9 цаг | 350 000₮ | 3 150 000₮ |
| 3 | Синхрон чихэвч /түрээс/ | 69 ш | 5 000₮ | 345 000₮ |
| Нийт дүн | | | | 10 495 000₮ |

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МӨРДӨХ ЖУРАМ

- Арга хэмжээний талаарх ерөнхий мэдээлэл, хөтөлбөрийг өгөх
- Арга хэмжээнд оролцох хүмүүсийн тоо өгөх
- Арга хэмжээ зохион байгуулахад бэлтгэл ажил шаардлагатай эсэх шаардлагатай бол бэлтгэл хийх өдөр, эхлэх дуусах цагийг тодорхой өгөх
- Арга хэмжээнд зориулсан сурталчилгааны самбар зэргийг байршуулахдаа зөвшөөрөл авах, тухайн объектын хана, тааз, багана болон тавилга эд хогшлыг гэмтээхгүйгээр байршуулах
- Арга хэмжээ дуусмагц гаднаас оруулж ирсэн тоног төхөөрөмж, сурталчилгааны самбар бусад нэмэлт эд зүйлсийг хураан авч явах

Захиалга өгсөн:  Х.Болд-Эрдэнэ / Албаны дарга /

Захиалга хүлээн авсан:  Ж.Долгоржав /ЗХНГ-ын мэргэжилтэн/

Гүйцэтгэлийг дүгнэсэн:

.....

.....

.....

.....